

МОНГОЛЫН ГҮН УХААНТАН ГАВЖ ЛУВСАНДОРЖ

Ш.Сонинбаяр - Гандантэгчэнлин хийд. Эрдэм Соёлын Хүрээлэн, доктор, гавж

Түлхүүр үг: Гавж Лувсандорж, монголын гүн ухаан, сайн ноён хан аймаг, Бодь мөрийн зэргийн эцсийн шинжилгээ эрхэм зарлигийн далайд орох сал онгоц.

Өгүүллийн товч: Эл өгүүллэгээр анх удаа ХҮIII-XIX зууны үеийн монголын гүн ухаантан, гавж Лувсандоржийн тухай судалгаа шинжилгээний хүрээнд татан оруулах оролдлогыг хийж байгаа болно. Тэрээр Ламын гэгээний гуравдугаар дүрийн хувилгаан Цэвээнжавчог, Брагри Ёнзин Дамцагдорж, Дозүн хувилгаан Галсандашжамц, Тив бүрүлгүү Иштүвдэнжамц, Чойнзад лам Дамбийдонмэ, Гачин ёнзэн Лувсаншийрэв зэрэг эрдэмтэн мэргэдээс судар тарнийн гүн ухааныг хөтлүүлэн заалгаж суралцсан юм. Лувсандорж гавжийн “Ламрим таажод” номыг Монголын их хүрээ зэрэг томоохон хүрээ хийдүүдэд үзэж судалдаг байжээ. 1970-аад онд Гандантэгчилэн хийдийн хамба лам номч мэргэн гавж С.Гомбожав, Шашны дээд сургуулийн багш гавж О.Дагважанцан, Т.Дамдинсүрэн нар зөвлөж хичээлийн сургаалтын хөтөлбөрт оруулан зааж байлаа.

Халхын Сайн Ноён Хан аймгийн Сайн Ноёны хошууны нутагт XIII жарны 44 дүгээр оны цагаан нохой жилд (1790 он) эцэг Түгж, эх Хонгор нарын хөвгүүн болж мэндэлжээ. Түүнийг нэг нутгийн номтой гэлэн Жанцанд шавь оруулж цагаан толгойн үсэг заалгасан ба тэрээр уншлагын номуудыг төвөггүй цээжилсэн байна. Лувсандорж нь багаасаа ухаан сэргэлэн тул багшийн заасныг гойд сайн сурч улмаар зурхайч Рэгзэнгээр одон зурхайн ухааныг заалгажээ. Тэрээр арванесөн настайдаа Гачэн лам Лувсангэлэгээс гэцэл санваар хүртжээ. Олон номтой мэргэдийн өлгий болсон Ламын гэгээний хийдэд (Гандандидлэн) шавилан сууж гүн ухааны дацан сургуульд суралцсан юм. Ламын гэгээний хүрээнд байхдаа да лам Лувсангомбоор нэг жил учир шалтгааны ухаан заалган суралцсан байна. Төвдийн Жачүн хийдийн лхаарамба Гэндүнняндагийг шүтэж гүн ухааны парчин, дундад үзлийн онолыг суралцсан юм. Хааяа Өвөр Монголын Урад дунд гүний хошууны Бадгарчойлин хийдэд очиж зод дүлбааны номд суралцаж байсан юм. Ламын гэгээний гуравдугаар дүрийн хувилгаан Цэвээнжавчог, Брагри Ёнзон Дамцагдорж, Дозүн хувилгаан Галсандашжамц, Тив бүрүлгүү Иштүвдэнжамц, Чойнзад лам Дамбийдонмэ, Гачин ёнзэн Лувсаншийрэв зэрэг эрдэмтэн мэргэдээс судар тарнийн гүн ухааныг хөтлүүлэн заалгаж суралцсан юм. Лувсандорж 33-н насандаа 1822 онд ламын гэгээний хүрээ Дэдлинд гавжийн дамжаа барьж гавж болжээ. Гавж Лувсандоржийг ламын гэгээний хүрээнээс залж Сайн Ноён хан аймгийн гол хүрээ Ганданцэпиллэн хийдэд суулгасан бөгөөд тэнд олон шавь нарт буддын гүн ухааны номыг ихэвчлэн зааж хөтөлдөг байв. Гавж Лувсандорж нь Сайн Ноён хан аймгийн хүрээ Ганданцэпиллэн хийдийн гэсгүй, чойр дацангийн хамба зэрэг өндөр албан тушаалыг хашсаны дээр тус хийдийн дэглэм журам, дацангуудын сургалтыг сайжруулж байсан түүхтэй.

Гавж Лувсандоржийн товч намтрыг түүний шавь равжамба Галсанжунай Төвд хэлээр зохиосон байна. Гандантэгчилэн хийдийн гэвш Ш.Иштавхай гавж Лувсандоржийн

зохиолын сүмбүмийн гарчигийг товч намтрын хамт Энэтхэгт хэвлүүлсэн байна. Түүний зохиолуудын дотроос хамгийн алдартай хоёр номын тухай голлон өгүүлэе. Судрын гүн ухааны гол зохиол Богд Зонховын айлдсан “Бодь мөрийн зэрэг” хэмээх номын утгыг ойлгоход хялбар болгож буддын гүн ухааны цанид чойрын дацанд мэтгэлцээний аргаар ном хаялцуулах сургалтын арга барилаар зохиосон “Бодь мөрийн зэргийн эцсийн шинжилгээ эрхэм зарлигийн далайд орох сал онгоц” хэмээх номоо зургаан томоохон бүлэгт багтааж зохиосон байна. Энэ зургаан хэсэг нь дотроо:

1. Өмнөх бэлтгэл ерийн номлол
2. Бага төрөлхтний аймаг
3. Дунд төрөлхтний аймаг
4. Их төрөлхтний аймаг
5. Амирлан оршихуйн аймаг
6. Үлэмж үзэхүйн аймаг гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Гавж Лувсандорж нь өөрийн багш Брагри ёнзин Дамцагдоржийн “Манай энд сүм хийдүүдэд лам хуварга цөөн. Чойрын таван ботийн номыг хэлэлцдэг том хийдүүд шиг олон зиндаагаараа нарийвчлан хэлэлцэхэд бэрхшээлтэй боловч эрхэм зарлиг бүхний шимийг хураангуйлсан “Бодь мөрийн зэрэг”-ийг номлох сонсоход хичээнгүйлэн үйлдвээс тус ихтэй” хэмээн зарлиглаж айлдсан хийгээд V Богд Жэвзүндамба бээр ч зарим хийдүүдэд “Бодь мөрийн зэрэг”-ийн хэлэлцээ байгуулж чадвал хэрэг их байгаа гэж айлдсаныг ч сэтгэлдээ хадгалан энэхүү “Бодь мөрийн зэргийн эцсийн шинжилгээ эрхэм зарлигийн далайд орох сал онгоц” хэмээх номоо бичиж байгаад Тивү бүрүлгүү Иштүвдэнжамцад болгоолгосонд сайшаан магтаж гүйцээн зохиох хэрэгтэйг сануулсны дагуу зохиосон байна. Лувсандорж гавжийн “Ламрим таажод” номыг Монголын их хүрээ зэрэг томоохон хүрээ хийдүүдэд үзэж судалдаг байжээ. 1970-аад онд Гандантэгчилэн хийдийн хамба лам номч мэргэн гавж С.Гомбожав, Шашны дээд сургуулийн багш гавж О.Дагважанцан, Т.Дамдинсүрэн нар зөвлөж хичээлийн сургаалтын хөтөлбөрт оруулан зааж байлаа.

Лувсандорж гавжийн өөр нэг алдартай бүтээл нь Богд Зонховын айлдсан тарнийн гүн ухааны үндсэн гол ном “Тарнийн их зэрэг” хэмээх номыг судлахад хэрэг болгож “Нууц Дандарын очир хөлгөний мөрийн зэргийн шимийг нотлон буулгасан Дандарын аймгийн далайд орох сал онгоц” хэмээх зохиол юм. Энэ алдарт бүтээлээ гавж Лувсандорж өөрийн багш Брагри ёнзин Дамцагдоржийн зөвлөсний дагуу зохиосон байна. Үүний учир нь багш Брагри ёнзин Дамцагдоржид өмнө нь зохиосон “Ламрим таажод” номоо барьж өргөсөнд баясан таалж одоо үүнтэйгээ адилхан тарнийн мөрийн зэрэг хэмээх зохиол хэрэгтэй хэмээн дахин дахин айлдсаны дагуу гүйцээн зохиосон байна. Энэ тухай “Дандарын мөрийн зэргийн эцсийн шинжилгээ” хэмээх зохиолынхоо төгсгөлийн үгэндээ тодорхой бичсэн байна.

Бурхан багшийн айлдсан судрын гүн ухаан, тарнийн гүн ухаан хоёрыг судлахад ном хаялцах мэтгэлцээний хэлбэрээр бичигдсэн Лувсандорж гавжийн дээрхи хоёр зохиолыг Монгол, төвдийн эрдэмтэн мэргэд шагшин магтацгаадаг юм. Энэ утгаараа Лувсандорж гавжийн судар тарнийн гүн ухааны охь шим болсон “Бодь мөрийн зэргийн эцсийн шинжилгээ”, “Дандарын мөрийн зэргийн эцсийн шинжилгээ” номууд нь гүн ухаан чойрыг судлах аргаар зохиогдсон нь Монголчуудын гүн ухааны мэдлэг хэр зэрэг өндөр байсныг харуулж байгаа юм.